



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/386

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, 60.1.5, 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний Статистикийн хорооны дарга, Аймгийн Засаг дарга, Статистикийн хэлтсийн дарга нарын байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтийг хангах, нутаг дэвсгэрийн нэгжийн үйл ажиллагааны статистикийн, мэдээллийн санг бий болгох, орон байраар хангах зорилгоор 20,000,000 (хорин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баярбаатар)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ